**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА**
**ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ХОА-2026/016/НА-СТА-ТТЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Ховд хот<br>2026 он | Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар<br>Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn<br>Аудитын менежер: А.Цэцэгсүрэн<br>Утас:70432545<br>Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn<br>Аудитор: Д.Нямгарав<br>Утас: 99478813<br>Цахим хаяг: nyamgaravd@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ........ 3

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ........ 5

2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан ........ 5

2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 5

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 6

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 7

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 8

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 8

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ........ 9

3.1 Зөвлөмж ........ 9

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ........ 11

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл ........ 13

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТТЗ | Төсвийн төвлөрүүлэн захирагч |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| ТӨҮГ | Төрийн өмчит үйлдвэрийн газар |
| ЕБС | Ерөнхий боловсролын сургууль |
| ОНӨААТҮГ | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар |

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ХОВД АЙМАГ ДАХЬ
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг
Утас/Факс: (976)-7043-3061
Email: khovd@audit.gov.mn

2026.03.25 № 276

танай ____________-ны №____________-т

БУЛГАН СУМЫН
ЗАСАГ ДАРГА Б.ГАНТУЛГА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Булган сум нь 2025 онд малын тоо толгойгоор 286.4 мянган мал тоолуулсан нь Ховд аймгийн нийт 3.1 сая малын 9.2 хувийг эзэлж байна. Харин хүн амын өсөлт шилжилт хөдөлгөөнөөр урьдчилсан байдлаар 10609 хүн амтай байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 онд хэрэгжүүлэх 6 хөтөлбөрийн 65 арга хэмжээний зардалд 5,782.7 сая төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 4,604.5 сая төгрөгийг зарцуулснаас 3,800.5 сая төгрөгийг урсгал зардалд, 1,080.9 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангийн шилжих болон шинээр эхлэх 20 хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээнд тус тус зарцуулсан байна.

**Бусад асуудлын хэсэг**

8426050684

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 бодлого зорилтын хүрээнд 65 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 91.8 хувийн гүйцэтгэлтэйгээр аймгийн Засаг даргаар үйл ажиллагаагаа дүгнүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.
Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.
Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан (мянган төгрөгөөр)

| № | Дансны нэр, төрөл | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | **1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,690,699.85** | **2,654,353.83** |
| 2 | 1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ | 1,138,364.41 | 1,512,320 |
| 3 | 1.1.3 АВЛАГА | 416,825.22 | 694,588.11 |
| 4 | 1.1.4 УРЬДЧИЛГАА | 88,979 | 389,900 |
| 5 | 1.1.5 БАРАА МАТЕРИАЛ | 46,531.22 | 57,545.72 |
| 6 | **1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **11,191,337.28** | **16,926,837.87** |
| 7 | 1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 11,191,337.28 | 16,926,837.87 |
| 8 | 1.2.2.02 Биет хөрөнгө | 10,949,616.68 | 16,685,117.27 |
| 9 | 1.2.2.03 Биет бус хөрөнгө | 241,720.6 | 241,720.6 |
| 10 | **1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2** | **12,882,037.13** | **19,581,191.7** |
| 11 | **2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **4,549.32** | **836,644.22** |
| 12 | 2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 4,549.32 | 836,644.22 |
| 13 | 2.1.1.03 Өглөг | 4,549.32 | 836,644.22 |
| 14 | 2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 12,877,487.81 | 18,744,547.48 |
| 15 | 2.2.1 Засгийн газрын хувь оролцоо | 12,877,487.81 | 18,744,547.48 |
| 16 | 2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал | 1,313,277.67 | 1,313,277.67 |
| 17 | 2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн | 11,230,249.99 | 17,097,309.65 |
| 18 | 2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 333,960.16 | 333,960.16 |
| 19 | **2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5** | **12,882,037.13** | **19,581,191.7** |

### 2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (мянган төгрөгөөр)

| № | Дансны нэр, төрөл | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН** | **14,690,977.8** | **16,456,806.5** |
| 2 | 1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО | 2,454,558.69 | 2,474,833.82 |
| 3 | 1.1.1.03.1 Орлогын албан татвар | 2,311,360.11 | 2,224,994.99 |
| 4 | 1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар | 2,401,835.23 | 2,369,014.42 |
| 5 | 1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | -90,475.12 | -144,019.43 |
| 6 | 1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар | 73,164.02 | 61,452.05 |
| 7 | 1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж | 70,034.56 | 188,386.77 |
| 8 | 1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 5,615,426.91 | 9,748,577.99 |
| 9 | 1.1.1.04.3 Тусламжийн орлого | 0.0 | 1,552,523.34 |
| 10 | 1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 2,872,292.39 | 0.0 |
| 11 | **1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **9,318,668.8** | **10,576,527,4** |
| 12 | **1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ** | **9,318,668.8** | **10,576,527,4** |

| | | | |
|---|---|---|---|
| 13 | **1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **5,512,184.6** | **6,113,039.16** |
| 14 | 1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 977,702.08 | 1,349,537.82 |
| 15 | 1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 119,120.69 | 142,663.54 |
| 16 | 1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 1,718,187.05 | 1,802,568.68 |
| 17 | 1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал | 1,846,588.77 | 1,844,595.59 |
| 18 | 1.1.2.01.1.05 Нормативт зардал | 2,498 | 4,405.85 |
| 19 | 1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал | 14,482.3 | 44,442.63 |
| 20 | 1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал | 17,975.3 | 19,928.8 |
| 21 | 1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 90,107.27 | 62,619.67 |
| 22 | 1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал | 725,523.14 | 842,276.57 |
| 23 | 1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 3,806,484.2 | 4,463,488.3 |
| 24 | **1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **5,372,308.99** | **5,880,279.09** |
| 25 | 1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 6,638.05 | 14,960.55 |
| 26 | **1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)** | **-6,638.05** | **-14,960.55** |
| 27 | **1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)** | **5,365,670.94** | **5,865,318.54** |

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан (мянган төгрөгөөр)

| **№** | **Дансны нэр, төрөл** | **Өмнөх он** | **Тайлант он** |
|---|---|---|---|
| **1** | **1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **5,795,267.45** | **5,839,845.03** |
| 2 | 1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО | 2,454,558.69 | 2,474,833.82 |
| 3 | 1.1.1.1.03.1 Орлогын албан татвар | 2,311,360.11 | 2,224,994.99 |
| 4 | 1.1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | -90,475.12 | -144,019.43 |
| 5 | 1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар | 73,164.02 | 61,452.05 |
| 6 | 1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж | 70,034.56 | 188,386.77 |
| 7 | 1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж | 29,728.49 | 37,940.73 |
| 8 | 1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр | 29,668.87 | 142,276.04 |
| 9 | 1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр | 10,637.2 | 8,170 |
| 10 | 1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 468,416.38 | 3,365,011.21 |
| 11 | 1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого | 468,416.38 | 643,500.27 |
| 12 | 1.1.1.1.04.3 Тусламжийн орлого | 0.0 | 1,559,873.65 |
| 13 | 1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 0.0 | 1,161,637.3 |
| 14 | 1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 2,872,292.39 | 0.0 |
| 15 | **1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **3,362,653.85** | **3,971,795.91** |
| 16 | 1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ | 3,362,653.85 | 3,971,795.91 |

| | | | |
|---|---|---|---|
| 17 | 1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 3,304,869.25 | 3,741,702.36 |
| 18 | 1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,109,848.59 | 1,270,691.13 |
| 19 | 1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 168,242.34 | 161,086.8 |
| 20 | 1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 1,725,128.27 | 1,802,568.68 |
| 21 | 1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал | 79,746.8 | 83,439.5 |
| 22 | 1.1.1.2.01.1.05 Нормативт зардал | 1,178.7 | 768.8 |
| 23 | 1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал | 14,482.4 | 34,662.15 |
| 24 | 1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал | 16,485.7 | 18,398.8 |
| 25 | 1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 104,670.24 | 222,798.78 |
| 26 | 1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал | 85,086.21 | 147,287.72 |
| 27 | 1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 57,784.59 | 230,093.55 |
| 28 | **1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **2,432,613.61** | **1,868,049.12** |
| 29 | 1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН | 1,705,618.7 | 1,232,124.03 |
| 30 | 1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 1,705,618.7 | 1,232,124.03 |
| 31 | 1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр | 1,705,618.7 | 1,232,124.03 |
| 32 | **1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **-1,705,618.7** | **-1,232,124.03** |
| 33 | 1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 62,541 | 261,969.5 |
| 34 | 1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | -62,541 | -261,969.5 |
| 35 | **1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **664,453.9** | **373,955.59** |
| 36 | **1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **473,910.51** | **1,138,364.41** |
| 37 | **1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **1,138,364.41** | **1,512,320** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (мянган төгрөгөөр)

| **№** | **Дансны нэр, төрөл** | **Засгийн газрын хувь оролцооны нийт дүн** | **Нийт цэвэр хөрөнгө /өмч** |
|---|---|---|---|
| 1 | **1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **7,511,816.87** | **7,511,816.87** |
| 2 | 1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 12,928.8 | 12,928.8 |
| 3 | 1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 7,524,745.67 | 7,524,745.67 |
| 4 | 1.1.1.1.2 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | -12,928.8 | -12,928.8 |
| 5 | 1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн | 5,365,670.94 | 5,365,670.94 |
| 6 | 1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 12,877,487.81 | 12,877,487.81 |
| 7 | 1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 12,877,487.81 | 12,877,487.81 |

| | | | |
|---|---|---|---|
| 8 | 1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 1,741.12 | 1,741.12 |
| 9 | 1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 12,879,228.93 | 12,879,228.93 |
| 10 | 1.7 Тайлант үеийн үр дүн | 5,865,318.54 | 5,865,318.54 |
| 11 | **1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **18,744,547.48** | **18,744,547.48** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөгөөр)

| № | Дансны нэр, төрөл | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН** | **4,865,451.1** | **5,031,865.2** |
| **2** | **3.1.01.1.1 Татварын орлого** | **2,268,862.7** | **2,474,833.5** |
| 3 | 3.1.01.1.1.1 Орлогын албан татвар | 2,268,862.7 | 2,474,833.5 |
| 4 | 3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар | 2,268,862.7 | 2,474,833.5 |
| 5 | 3.1.01.1.1.1.1.01 Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого | 1,779,709.40 | 1,976,623.40 |
| 6 | 3.1.01.1.1.1.1.02 Үйл ажиллагааны орлого | 50,000.00 | 59,165.00 |
| 7 | 3.1.01.1.1.1.1.03 Хөрөнгийн орлого | 142,500.00 | 141,259.90 |
| 9 | 3.1.01.1.1.1.1.07 Шууд бус орлого | 235,500.00 | 191,965.90 |
| 10 | 3.1.01.1.1.1.2 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | (144,019.4) | (144,019.4) |
| 12 | **3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар** | **63,940.0** | **34,915.1** |
| 16 | 3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж | **141,232.7** | **214,923.6** |
| 17 | 3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж | 141,232.7 | 214,923.6 |
| **27** | **3.1.01.1.2 Татварын бус орлого** | **2,596,588.4** | **2,557,031.7** |
| 28 | 3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого | 111,400.0 | 172,648.3 |
| 32 | 3.1.01.1.2.3 Тусламжийн орлого | 1,323,551.1 | 1,222,746.1 |
| 35 | 3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 1,161,637.3 | 1,161,637.3 |
| **37** | **3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **5,781,903.3** | **4,657,909.6** |
| 38 | **3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,539,950.5** | **3,314,942.8** |
| 39 | 3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 3,539,950.5 | 3,314,942.8 |
| 40 | 3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,292,066.4 | 1,126,458.1 |
| 45 | 3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 161,086.8 | 161,086.8 |
| 51 | 3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 1,872,565.4 | 1,781,900.9 |
| 55 | 3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал | 34,669.5 | 30,672.4 |
| 59 | 3.1.01.2.1.1.5 Нормативт зардал | 1,520.1 | 768.8 |
| 61 | 3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал | 35,724.8 | 34,662.1 |
| 64 | 3.1.01.2.1.1.7 Томилолт, зочны зардал | 19,537.6 | 18,398.8 |
| 66 | 3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 84,169.8 | 118,172.5 |
| 73 | 3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал | 38,610.1 | 42,822.4 |
| 76 | 3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | - | |
| 83 | **3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **1,978,082.0** | **1,080,997.3** |
| 86 | 3.1.01.2.2.4 Бусад хөрөнгө | - | - |
| 87 | **3.1.01.2.3 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | **263,870.8** | **261,969.5** |
| 92 | **4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **-** | **1,138,364.4** |
| 93 | **5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **-** | **1,512,320.0** |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөгөөр)

| Дансны код | Дансны нэр, төрөл | Тайлант он |
|---|---|---|
| 1 | 1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 337,127.5 |
| 12 | 1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 337,127.5 |
| 122 | 1.1.1.1.1.1 Тусламжийн орлого | 337,127.5 |
| 1221 | 1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/ | 337,127.5 |

| | | |
|---|---|---|
| 12213 | 1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого | 337,127.5 |
| 350013 | 1.1.1.1.1.1.1.1.3 ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 314,670.5 |
| 350014 | 1.1.1.1.1.1.1.1.4 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 22,457.0 |
| 350015 | 1.1.1.1.1.1.1.1.5 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | |
| II | 1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 310,289.8 |
| 21 | 1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ | 159,163.1 |
| 210 | **1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **119,163.1** |
| 2104 | 1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал | 3,715.9 |
| 2108 | 1.1.1.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 10,981.9 |
| 2109 | 1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал | 104,465.3 |
| 4 | **1.1.1 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ** | **26,837.6** |
| 5 | 1.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | -26,837.6 |
| 6 | 1 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | -26,837.6 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 278,993.3 мянган төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 244,873.5 мянган төгрөгийн 4 алдааг залруулан 34,119.8 мянган төгрөгийн 4 заалт бүхий 2 зөвлөмж өглөө. Үүнд:

- ОНХС-ийн хөрөнгөөр тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр арга хэмжээг хүлээн аваагүй 161,600.0 мянган төгрөгийг урьдчилж гарсан зардлаар бүртгээгүй,
- Тус сангийн тайлант үеийн үр дүнг 17,315.7 мянган төгрөгөөр бууруулан тайлагнасан,
- Хоршоо хөгжүүлэх сангийн тайланд 35,109.2 мянган төгрөгийг авлагаар тусгаагүй,
- Хоршоо хөгжүүлэх сангийн авлага дутуу тусгаснаар тайлант үеийн үр дүнг 30,846.6 мянган төгрөгөөр бууруулан тайлагнасныг аудитын явцад залруулсан.

Дээрх алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д ‘’аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх’’ заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулсан.

Залруулагдаагүй нийт 34,119.8 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон ерөнхий материаллаг байдлын 185,139.1 мянган төгрөгийн түвшингээс “бага” байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 34,119.8 мянган төгрөгийн 3зөрчил[2] илэрснээс, алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 4 заалт бүхий 34,119.8 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

### 3.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 3.1.1 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбоотой асуудал

Илрүүлэлт: Сумын Засаг даргын мөрийн хөтөлбөр болон цаг үеийн холбогдолтой шууд зардал болох тэмцээн уралдаан, сар шинийн золголт, сургалт, *2025 оны 02 дугаар сард 10.0 сая төгрөгөөр Улаанбаатар хотод хөрөнгө оруулалтын чуулга уулзалттай гэж сумын Засаг даргын тамгын газрын нярвын харилцах дансаар дамжуулан гаргахдаа иж бүрдэл дутуу баримтаар гүйлгээ* хийсэн зэрэг нийт 34,119.8 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас зарцуулсан

[1] *Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглэлээгүй орхисон/,*

нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-д "хуулиар зөвшөөрөөгүй бусад", 13 дугаар зүйлийн 13.5-д "Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр зөвхөн орон нутгийн иргэдийн санал авсан, хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан холбогдох зөвшөөрөл олгогдсон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ", 13.6-д "Иргэдээс санал авч дэмжигдсэн тохиолдолд Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, өрхийн амьжиргааг дэмжих болон иргэдэд жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэхэд тоног төхөөрөмжийн болон арга зүйн дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн сургалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлж болно", 15 дугаар зүйлийн 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", 15.1.8-д "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах", 15.2.7-д "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх" гэсэн заалт нь санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зориулалт бусаар үрэлгэн зарцуулахыг таслан зогсоож, дотоод хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэн ажиллах.

### 3.1.2 Төрийн сан, дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: “Минжит Булган Таван Цагариг” спорт цогцолборын дарга, нярав нар нь 2025 онд урсгал засварын ажилд байгууллагынхаа хувийн харилцах дансаараа бүрдүүлсэн боловч байгууллагын дансанд төвлөрүүлж зарцуулаагүй байна. Санхүүгийн анхан шатны баримтаар тогтоогдохгүй, мөн тайлант онд эдийн засгийн ангилал зөрчин гүйлгээ хийсэн, эрх бүхий байгууллагаас тогтоосон төлбөрийн актыг төсвөөс төлж гүйлгээ хийхэд төрийн сангийн хяналт тавиагүй нь Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.4.10-д “Төрийн сан төсвийн байгууллагын төлбөрийн хүсэлтийг төлбөр гүйцэтгэхэд үндэслэх санхүүгийн анхан шатны баримттай тулган, батлагдсан төсвийн зарцуулалтын эрх, хөтөлбөр, зориулалт, арга хэмжээ, эдийн засгийн ангилал, ирүүлсэн мэдээлэлд үндэслэн ажлын 3 өдрийн дотор төлбөрийг гүйцэтгэх ба шаардлага хангаагүй тохиолдолд гүйлгээг буцаана”

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн орлогын бүрдүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах, хууль журам зөрчсөн гүйлгээг гаргахгүй байх, санхүүгийн сахилга батыг дээшлүүлэхэд анхаарах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 05 дугээр сарын 25-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

# 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

## 4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Алдааны утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс: Залруулсан | | Үүнээс: Залруулаагүй | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | тоо | Дүн | тоо | Дүн | Тоо | Дүн |
| **1** | **2** | **3** | **4** | **5** | **6** | **7** | **8** | **9** | **10** | **11** | **12** | **13** | **14** |
| Орон нутгийн хөгжлийн сан | Сумын халуун усны санхүүжилтээр 136.0 сая төгрөг, 1-р сургуулийн дулаан холболтын ажилд 25.6 сая төгрөгийг олгож урьдчилж гарсан зардалд тусгаагүй | 1 | 161,600.0 | 1 | 161,600.0 | | | 1 | 161,600.0 | | | | |
| Орон нутгийн хөгжлийн сан | Урьдчилж гарсан зардалд дутуу тусгаснаар тайлант үеийн үр дүнг бууруулсан | 1 | 17,315.7 | 1 | 17,315.7 | | | 1 | 17,315.7 | | | | |
| Хоршоо хөгжүүлэх сан | 2025 оны жилийн эцсийн байдлаар 3 иргэнээс 23,000.0 мянган төгрөгийн үндсэн зээл, 6 иргэн аж ахуйн нэгж байгууллагаас 12,109.2 мянган төгрөгийн хүү алдангийн тооцоогүй, авлагын данс бүртгэлд тусгаагүй | 1 | 35,109.2 | 1 | 35,109.2 | | | 1 | 35,109.2 | | | | |
| Хоршоо хөгжүүлэх сан | Авлагыг дутуу тусгаснаар тайлант үеийн үр дүнг бууруулсан | 1 | 30,848.6 | 1 | 30,848.6 | | | 1 | 30,848.6 | | | | |
| **ДҮН** | | **4** | **244,873.5** | **4** | **244,873.5** | | | **4** | **244,873.5** | | | | |

## 4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Аудитад хамрагдс | Алдаа, зөрчлийн товч утга | Нийт алдаа, зөрчлийн дүн | Үүнээс: |
|---|---|---|---|

| ан байгууллагын нэр | | Тоо | Дүн | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| Төрийн сан, дотоод хяналт | “Минжит Булган Таван Цагариг” спорт цогцолборын дарга, нярав нар нь 2025 онд урсгал засварын ажилд байгууллагынхаа хувийн харилцах дансаараа бүрдүүлсэн боловч байгууллагын дансанд төвлөрүүлж зарцуулаагүй байна. Санхүүгийн анхан шатны баримтаар тогтоогдохгүй, мөн тайлант онд эдийн засгийн ангилал зөрчин гүйлгээ хийсэн, эрх бүхий байгууллагаас тогтоосон төлбөрийн актыг төсвөөс төлж гүйлгээ хийхэд төрийн сангийн хяналт тавиагүй. | 1 | - | | | | | 1 | - | | |
| **ДҮН** | | **1** | **-** | | | | | **1** | **-** | | |

**4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** /мянган төгрөгөөр/

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Алдаа, зөрчлийн товч утга | Нийт алдаа, зөрчлийн дүн | | Үүнээс: | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Дүн | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн | |
| | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| Орон нутгийн хөгжлийн сан | Сумын Засаг даргын мөрийн хөтөлбөр болон цаг үеийн холбогдолтой шууд зардал болох тэмцээн уралдаан, сар шинийн золголт, сургалт, 2025 оны 02 дугаар сард 10.0 сая төгрөгөөр Улаанбаатар хотод хөрөнгө оруулалтын чуулга уулзалттай гэж сумын Засаг даргын тамгын газрын нярвын харилцах дансаар дамжуулан гаргахдаа иж бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн | 1 | 34,119.8 | | | | | 1 | 34,119.8 | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **ДҮН** | **1** | **34,119.8** | | | | | **1** | **34,119.8** | | |

## 5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| 2 | ОНХСан | 1 | | 1 | | | | | |
| 3 | ХХСан | 1 | | 1 | | | | | |
| 4 | ОНӨҮГ | 1 | 1 | | | | 1 | | |
| | **НИЙТ** | **4** | **2** | **2** | | **1** | **1** | | |